

3.1.3	Төсвийн төлөвлөлт, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж төсвийн ил тод байдал, сахилга батыг сайжруулж, шилэн дансны хэрэгжилт 2020 онд 91.3 байсныг 2024 онд 98 хувьд хүргэнэ.	Шилэн дансны хэрэгжилтийн дундаж хувь	хувь	2021-2024	2023	96	98	2020 онд Шилэн дансны хэрэгжилт 91.3 хувтай байсан ба 2024 оны 3-р улиралын байдлаар орон нутгийн болон төсвийн байгууллага, ОНӨҮГ-ийн 148 байгууллага тогтоосон хугацаанд байршуулах нийт мэдээллээс 97.1 хувь буюу 19254 мэдээлийг хугацаанд нь, 2 хувь буюу 395 мэдээллийг хугацаа хожимдуулан цахим сүлжээнд байршуулан мэдээлж, нийт мэдээлэх мэдээний гүйцэтгэл 99.1 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.	99.1
3.1.3.1	Эрсдэлд суурилсан дотоод аудитыг бэхжүүлж, төлөвлөгөөний дагуу орон нутгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг зохион байгуулах	Хяналт, шалгалт хийсэн тоо	тоо	2021-2024	2023	70	64	2021 оны төлөвлөгөөт шалгалтаас 96 баримтын, явцын 1, аудит 1, нийт 98, төлөвлөгөөт бус 5 байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна. 2022 онд 80 байгууллага, нэгжид хяналт шалгалт хийгдснээс шалгалтаар давхардсан тоогоор 113 удаагийн зөвлөмж, 5 удаагийн 135,186.0 мянган төгрөгийн зөрчил арилгуулахаар хугацаатай албан шаардлага, 4 удаагийн 2,518.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон байна. 2023 онд 74 байгууллага, нэгжид 7 удаагийн 5,244.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож хэрэгжилт 100 хувьтай, зөрчил арилгах 14 удаагийн 860.6 сая төгрөгийн хугацаатай албан шаардлага өгөгдсөнөөс хэрэгжилт 100 хувьтай, нийт 146 удаагийн зөвлөмж өгөгдсөнөөс хэрэгжилт 98 хувьтай байна. 2024 оны 3 дугаар улиралын байдлаар 39 нэгжид төлөвлөгөөт хяналт шалгалт 4 нэгжид төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгдсэн байна.	100
		Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	хувь	2021-2024	2023	88	90	2022 онд 80 нэгжийн шалгалтын явцад давхардсан тоогоор 113 зөвлөмж өгсөн ба зөвлөмжийн хэрэгжилт 92%-тай, 2023 онд 146 удаагийн зөвлөмж өгөгдсөнөөс хэрэгжилт 98 хувьтай байна. 2024 оны 3-р улиралын байдлаар 39 нэгжийн шалгалтын явцад давхардсан тоогоор 83 зөвлөмж өгсөн ба 44 байгууллага нэгжийн зөвлөмжийн хэрэгжилт гарч 39 нэгжийн зөвлөмжийн хэрэгжилт ирүүлэх хугацаа болоогүй байна.	100